



ХОВД АЙМАГ  
МЯНГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/29

Баянхошуу


┌ Сурагчдад хүндэтгэл үзүүлэх тухай ┐

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулиа амжилттай төгсөж байгаа нийт сурагчдад аяр хүргэж, сургуулийн тэргүүний сурагч Т.Батнасан, Шилдэг сурагч Л.Насанжаргал нарт хүндэтгэл үзүүлсүгэй.

2.Хүндэтгэлийн арга хэмжээнд шаардагдах 186.000/Нэг зуун наян зургаан мянган/төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Ж.Долгор/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДАВААДОРЖ



ХОВД АЙМАГ  
МЯНГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/41

Баянхошуу

Бэлчээрийг хуваарьтай ашиглуулах  
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 б дахь заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжин хаваржааны бүс нутгийг хамгаалах зорилгоор гадны малчдыг сумын нутаг дэвсгэрт жил бүрийн 5 дугаар сарын 1 нээс 11 дүгээр сарын 1 ний өдрийг хүртэлх хугацаанд нутаглахыг хориглож, хориглосон бүс нутгийн нэрсийг хавсралтаар баталсугай.


2.Малчдын хадлан бэлтгэж дуусах хугацаа буюу жил бүрийн 08 дугаар сарын 25 ныг хүртлэх хугацаанд хадлангийн бүс нутагт айл буух, мал бэлчээхийг хориглосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын бэлчээр хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ДАВААДОРЖ



ХОРИГЛОСОН БҮС НУТГИЙН  
НЭРС

1. Намбулаг
2. Зүлэгт
3. Амаа бор хэрсэн
4. Улаан хаалгын эх
5. Сойсгоо
6. Хойд цалуу
7. Зүлэгт
8. Хөтлийн хаяа
9. Улааны таг
10. Маадай
11. Баярт
12. Улааны ар
13. Гэндэн
14. Зараа
15. Таван толгой
16. Чаргат
17. Цахирын худаг
18. Тавхай
19. Бурьгил
20. Баянбулагийн адаг